**ДУНДГОВЬ АЙМГИЙН**
**ДЭЛГЭРЦОГТ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН**
**ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2021 оны 01 сарын 29 өдөр Дугаар 07 Амардалай

Сум хөгжүүлэх сангийн Тэргүүлэх чиглэл,
зээлийн дээд хэмжээг батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1, Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор батлагдсан "Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих" журмын 3.2.1, 3.3.1 дэх заалтуудыг үндэслэн сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

1.Тухайн жилд жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх Тэргүүлэх чиглэл, төслийн зээлд олгох дээд хэмжээг хавсралтаар баталсугай.

2. Сум хөгжүүлэх сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийг сонгон шалгаруулах, зээлийг олгохдоо энэхүү Тэргүүлэх чиглэл, дээд хэмжээг баримтлан ажиллахыг Орон тооны бус зөвлөлүүдэд үүрэг болгосугай.

ДАРГА П.ТҮВШИНСАЙХАН

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны
01 дүгээр сарын 29 ны өдрийн 07 тоот тогтоолын хавсралт

Сум хөгжүүлэх сангийн Тэргүүлэх чиглэл

1. Үсчин, гоо сайхан
2. Эсгий гар урлал
3. Хүнсний ногоо, жимс жимсгэнэ, хүлэмжийн тариалалт
4. Мах махан бүтээгдэхүүний ангилсан савалгааны үйлдвэрлэл
5. Арьс шир, малын хоёрдогч түүхий эд боловсруулах үйлдвэрлэл
6. Туслах аж ахуй хөгжүүлэх үйлдвэрлэл
7. Нутгийн онцлогийг харуулсан бүтээгдэхүүний үйлдвэрлэл
8. Авто угаалга, засварын үйлчилгээ

Төслийн зээлийн дээд хэмжээ

1. Иргэнд 15,000,000₮
2. Аж ахуйн нэгжид 30,000,000₮
3. Сургалт, сурталчилгаа, бичиг хэрэг, нэгжний үнэ 750,000₮
4. СХС-ийн программ, лицензийн үнэ 132,000₮
5. Хяналтын зардал 618,000₮